БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Я.АМАРЖАРГАЛ

НИЙЛҮҮЛЭГЧ

ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭЛТ ХХК

Н.НАНСАЛМАА Н. Нансалмаа

# ШИНЭ КОРОНАВИРУСИЙН ХАЛДВАРЫН ҮЕД ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ, АРИУТГАЛЫН БОДИС, ОНОШЛУУР НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

Дугаар № 69

Улаанбаатар хот

Нэг талаас Эрүүл мэндийн яам (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **Халдваргүйжүүлэлт ХХК** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь гипохлориткальци худалдан авах гэрээг (цаашид “бараа” гэх) хорин зургаан сая дөрвөн зуун мянган төгрөгөөр (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

Хүснэгт 1. Нийлүүлэх бараа

| Д/Д | Барааны нэр, төрөл | Багцийн дугаа | Үйлдвэрлэгч, Улс | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгж үнэ /НӨАТ орсон/ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Гипохлорит кальци | 27 | БНХАУ | кг | 3000 | 8800 | 26,400,000 |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |

1. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг (Хорин зургаан сая дөрвөн зуун мянган) төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөр санхүүжүүлнэ.
2. Нийлүүлэгч нь 1 нэр төрлийн барааг 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрөөс 2020 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
3. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:

   Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
   Бусад шаардлагатай баримт бичиг[1];
   Тендер ба үнийн хуваарь;
   Гэрээний тусгай нөхцөл;
   Гэрээний ерөнхий нөхцөл;
   Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
   Санхүүжилтийн хуваарь.

   Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

4. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.

5. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.

6. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

Хүснэгт 1. Санхүүжилтийн хуваарь

| Д/Д | Барааны нэр, төрөл | Багцийн дугаа | Урьдчилгаа /төгрөг/ | Гүйцэтгэл /төгрөг/ |
|---|---|---|---|---|
| 1 | Гипохлорит | 27 | - | 26,400,000 |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | **Нийт дүн** | | - | 26,400,000 |

[1] Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

| | |
|---|---|
| | хэрэгслээр тээвэрлэн ХӨСҮТ-д болон эцсийн цэгт захиалагчид хүргэх хүртэл оногдуулсан бүх татвар хураамж, тээвэр, даатгал болон бусад зардлыг нийлүүлэгч бүрэн хариуцна. |

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН**

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

Эрүүл мэндийн яамны Эм, эмнэлгийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн хэлтсийн дарга
..........................................Г.Цэцэнсанаа

Эрүүл мэндийн яамны Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
..........................................Т.Бямбасүрэн

Эрүүл мэндийн яамны Эм, эмнэлгийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн
..........................................Т.Мөнхтуул

Эрүүл мэндийн яамны Хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн
..........................................Г.Бат-Эрдэнэ

Эрүүл мэндийн яамны ахлах нягтлан Бодогч
..........................................Х.Ариунтуяа

Эрүүл мэндийн яамны хуулийн хэлтсийн Мэргэжилтэн
..........................................Б.Мөнхцэцэг

*14210 Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр*

*Утас:263695*

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

Халдваргүйжүүлэлт ХХК-ийн Менежер
..........................................Ц.Наранханд

Хаяг: СБД 11 хороо, Ногоон нуурын гудамж-101, ProOne office 8 давхар 808 тоот
Утас: 70008981, 99147159
Регистрийн дугаар:2582007
Банк: Улаанбаатар хотын банк
Дансны дугаар: 2611028098